

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/115/СТА-ТӨҮГ

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	8
2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...	9
2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11 Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/481  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатарын их сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, бараа материалын тайлан, үлдэгдлийг сар бүр хянан, баталгаажуулж байх талаарх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Улаанбаатарын их сургуулийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 22-оос 2019 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнжаргал хянан удирдаж, аудитор Д.Нямдорж, А.Мөнхцоож, аудиторын туслах Ө.Рагчаа нарын бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Р.Цанжидмаа хяналт тавьж хэрэгжүүлэв.

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 1/047 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улаанбаатарын их сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Улаанбаатарын их сургуулийн эрдэмтэн багш нарын нөөц бололцоо, сургалтын материаллаг баазад түшиглэн шинжлэх ухаан үйлдвэрлэл, нийгмийн бүхий л салбарт бие даан ажиллах чадвартай, хувь хүний хөгжил, харилцааны өндөр соёлтой мэргэжлийн боловсон хүчнийг өөрийн болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэн бэлтгэх, сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн цогц бодлого бүхий сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Дээд боловсрол эзэмшүүлэх мэргэжил, сургалтын чиглэл, төвшин бүрээр зохих стандартыг үндэслэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулна гэж тодорхойлжээ.

Улаанбаатарын их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улаанбаатарын их сургуулийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан



- авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт өөрчлөлт гаргаагүй ба Нийгмийн даатгалын тухай хуульд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд татварын хөнгөлөлтөд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улаанбаатарын их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатарын их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улаанбаатарын их сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Повер Софт” ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Powersoft 4.8” програм хангамж ашигладаг байна.

Улаанбаатарын их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улаанбаатарын их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзсэнтэй холбоотой юм.

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны нийт зардал 2,069.5 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 41.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### **2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Улаанбаатарын их сургуулийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Газрын дахин үнэлгээг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр бүртгэсэн.
- Санхүүгийн байдлын тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 4.7 сая төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан.
- Боловсролын зээлийн сангийн 11.4 сая төгрөгийн санхүүжилтыг бүртгэхдээ бакалаврын сургалтын төлбөрийн орлогын дансыг бууруулж, дебет бичилт хийсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### **2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал**



Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	4.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	8.3	
	Дүн	6	12.4	

**2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**Асуудал 1: Зардлын данстай холбоотой**

Ажилтнуудад олгосон цалин, урамшуулалд даатгуулагчийн 2.6 сая, ажил олгогчийн 2.9 сая, нийт 5.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 0.8 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тус тус ногдуулаагүй, цалин урамшууллаас суутгасан 1.9 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг мэдүүлж, тайлагнаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараахь орлогод албан татвар ногдуулна: 8.1.1-д цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн ба хэмжилт, үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Улаанбаатарын их сургуулийн сургалтын төлбөрийн орлого, эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөрийн зардлын гүйцэтгэлийг нарийвчлан хянах нь зүйтэй гэж үзлээ.

**2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Улаанбаатарын их сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрт 493.7 сая, тогтмол зардлын санхүүжилтээр 76.8 сая, сургалтын төлбөрийн орлого 1,337.2 сая, үйл ажиллагааны бус орлого 27.0 сая, нийт 1,953.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 943.2 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,036.9 сая, улсын төсвөөс тогтмол зардлын 40.0 сая, нийт 2,148.8 сая төгрөгийн орлоготой буюу 10.0 хувь буюу 195.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд 2,456.2 сая төгрөгийн зардлын төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 2,069.5 сая төгрөгийн зардал гарч 386.7 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Улаанбаатарын их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаарх мэдээллийг шалгаж үзэхэд хуульд заасан хугацаанд жил улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад байршуулж, толилуулсан байна.

Улаанбаатарын их сургуулийн [usu.edu.mn](http://usu.edu.mn) сайтад шилэн дансны цэсийг холбож, шилэн дансны нэгдсэн цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 5 мэдээ, эхний хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлж, бусад мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50.0 хувьтай байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг шалгаж үзэхэд гэрээт багш нарт олгосон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл ногдуулаагүй дүнгээс хувь хүний орлогын албан татвар суутгасан зөрчил давтан гарсан тул төлбөрийн акт тогтоосон.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улаанбаатарын их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

**Кассын сар бүрийн тайланг хянаж, үлдэгдлийг тоолж, актаар баталгаажуулаагүй байна.**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж, кассын тайланг хянан, баталгаажуулж байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/123 дугаар албан бичиг ирүүлсэн.

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Сургалтын төлбөрийн 0.3 сая төгрөгийн авлага, татвар, нийгмийн даатгалтай тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу гарах

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Сургалтын төлбөр болон харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлж, баталгаажуулж байх.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/123 дугаар албан бичиг ирүүлсэн.

### **3.3 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1.5 сая төгрөгийг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **3.3.2 Эрсдэл:**

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу гарах

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Сургалтын төлбөр болон харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлж, баталгаажуулж байх.

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/123 дугаар бүхий албан бичиг ирүүлсэн.

### **3.4 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.4.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын эцсийн үлдэгдэл няравын тайлангаас 1.6 сая төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **3.4.2 Эрсдэл:**

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу гарах

#### **3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын үлдэгдлийг хянан баталгаажуулж, үнэн зөв бүртгэж, тайлагнах.

#### **3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/123 дугаар албан бичиг ирүүлсэн.

### **3.5 Орлогын данстай холбоотой асуудал**

#### **3.5.1 Илрүүлэлт:**

Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон урамшууллын 0.7 сая төгрөгийн орлогоор, нийгмийн даатгалын өглөгийг бууруулж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн ба хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **3.5.2 Эрсдэл:**

- Хууль тогтоомж, заавар журам зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу гарах

#### **3.5.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн хариу тайлбарыг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 1/123 дугаар албан бичиг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>811,191,634.93</u></b>	<b><u>478,259,054.20</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>371,399,584.07</b>	<b>427,465,920.36</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>371,399,584.07</b>	<b>427,465,920.36</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>371,399,584.07</b>	<b>427,465,920.36</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	334,162,245.95	410,717,165.03
<b>31220</b>	<b>Гадаад валют</b>	<b>37,237,338.12</b>	<b>16,748,755.33</b>
31223	Арилжааны банк дахь харилцах	37,237,338.12	16,748,755.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>158,880,365.54</b>	<b>42,067,884.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	158,830,883.00	42,067,884.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>49,482.54</b>	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	49,482.54	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>271,072,810.32</b>	-
34600	Урьдчилж гарсан зардал	271,072,810.32	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>9,838,875.00</b>	<b>8,725,249.84</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>9,838,875.00</b>	<b>8,725,249.84</b>
35420	Аж ахуйн материал	4,118,875.00	3,005,249.84
35470	Бусад хангамжийн материал	5,720,000.00	5,720,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,243,207,691.95</u></b>	<b><u>7,693,854,014.14</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,243,207,691.95</b>	<b>7,693,854,014.14</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,243,207,691.95</b>	<b>7,346,351,854.14</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,816,985,549.00	7,091,444,842.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-828,726,337.49	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	464,563,755.00	307,676,157.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	-391,897,814.61	-242,198,265.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	347,283,756.98	242,994,450.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-291,599,818.33	-189,924,967.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,000,000.00	19,665,000.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.60	-1,540,000.60
39217	Ном	114,138,602.00	118,234,637.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	347,502,160.00
39301	Програм хангамж	1,670,000.00	1,670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,670,000.00	-1,670,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-	347,502,160.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,054,399,326.88</u></b>	<b><u>8,172,113,068.34</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>417,586,741.30</u></b>	<b><u>62,921,613.30</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>417,586,741.30</b>	<b>62,921,613.30</b>

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>417,586,741.30</b>	<b>62,921,613.30</b>
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	417,586,741.30	62,921,613.30
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,636,812,585.58</u></b>	<b><u>8,109,191,455.04</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>2,636,812,585.58</u></b>	<b><u>8,109,191,455.04</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,004,868,431.00	2,352,370,591.00
51101	Өмч: - төрийн	2,004,868,431.00	2,352,370,591.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-28,756,196.42</b>	<b>50,594,176.83</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-28,756,196.42	-28,756,196.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	79,350,373.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	660,700,351.00	5,706,226,687.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН I=IV+V</b>	<b><u>3,054,399,326.88</u></b>	<b><u>8,172,113,068.34</u></b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,323,175,876.03</b>	<b>2,148,823,154.29</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,210,252,776.03</b>	<b>1,984,564,509.29</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,210,252,776.03</b>	<b>1,980,128,374.29</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,210,252,776.03	1,980,128,374.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,119,703,920.00	943,177,976.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,821,856.03	1,036,950,398.29
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,727,000.00	4,436,135.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>112,923,100.00</b>	<b>164,258,645.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>45,476,000.00</b>	<b>124,258,645.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	45,476,000.00	124,258,645.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>67,447,100.00</b>	<b>40,000,000.00</b>
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	67,447,100.00	40,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,305,538,616.68</b>	<b>2,069,472,781.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,305,538,616.68</b>	<b>2,069,472,781.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,302,583,616.68</b>	<b>2,064,735,468.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>721,588,752.09</b>	<b>857,488,182.82</b>
210101	Үндсэн цалин	721,588,752.09	857,488,182.82
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,544,206.02</b>	<b>98,734,038.70</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	76,544,206.02	98,734,038.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,332,619.72</b>	<b>55,343,291.82</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,275,457.00	16,077,290.00
210302	Түлш, халаалт	34,499,729.90	30,474,494.53
210303	Цэвэр, бохир ус	14,743,832.82	8,791,507.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,240,078.90</b>	<b>13,345,111.20</b>
210401	Бичиг хэрэг	1,606,570.00	1,030,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,671,517.90	8,425,733.20
210404	Ном, хэвлэл	4,961,991.00	3,888,678.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,725,400.00</b>	<b>519,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,725,400.00	519,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>49,710,100.00</b>	<b>53,975,783.00</b>
210604	Урсгал засвар	49,710,100.00	53,975,783.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,470,600.00</b>	<b>8,420,800.00</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,470,600.00	8,420,800.00

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,024,593.58</b>	<b>14,424,274.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,463,620.00	14,279,024.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	560,973.58	145,250.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>334,947,266.37</b>	<b>962,484,986.36</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,179,354.23	837,707,018.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,700,600.00	33,059,766.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,067,312.14	91,718,201.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,955,000.00</b>	<b>4,737,312.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,955,000.00</b>	<b>4,737,312.54</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	366,820.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>17,637,259.38</b>	<b>79,350,373.25</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>17,637,259.38</b>	<b>79,350,373.25</b>

### 4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,004,868,431.00</b>	<b>660,700,351.00</b>	<b>-46,393,455.77</b>	<b>2,619,175,326.23</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	17,637,259.35	17,637,259.35
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,004,868,431.00</b>	<b>660,700,351.00</b>	<b>-28,756,196.42</b>	<b>2,636,812,585.58</b>
D01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,004,868,431.00</b>	<b>660,700,351.00</b>	<b>-28,756,196.42</b>	<b>2,636,812,585.58</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>2,004,868,431.00</b>	<b>660,700,351.00</b>	<b>-28,756,196.42</b>	<b>2,636,812,585.58</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	5,045,526,336.21	-	<b>5,045,526,336.21</b>
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	347,502,160.00	-	-	<b>347,502,160.00</b>
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	79,350,373.25	<b>79,350,373.25</b>
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,352,370,591.00</b>	<b>5,706,226,687.21</b>	<b>50,594,176.83</b>	<b>8,109,191,455.04</b>

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,492,384,740.98</u></b>	<b><u>1,933,830,589.54</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,379,461,640.98</b>	<b>1,769,571,944.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,379,461,640.98</b>	<b>1,769,571,944.54</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,379,461,640.98</b>	<b>1,769,571,944.54</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	929,281,594.80	956,451,513.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	447,453,046.18	813,120,431.54
1200042	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,727,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>112,923,100.00</b>	<b>164,258,645.00</b>
<b>1320</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>45,476,000.00</b>	<b>124,258,645.00</b>
131007	Засгийн гарын тусгай сангаас санхүүжих	45,476,000.00	124,258,645.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>67,447,100.00</b>	<b>40,000,000.00</b>
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	67,447,100.00	40,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,572,588,890.01</u></b>	<b><u>1,863,153,060.57</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,572,588,890.01</b>	<b>1,863,153,060.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,571,388,890.01</b>	<b>1,859,918,060.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>655,606,108.62</b>	<b>796,307,562.03</b>
210101	Үндсэн цалин	655,606,108.62	796,307,562.03
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>149,737,463.64</b>	<b>171,460,706.19</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	149,737,463.64	171,460,706.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,477,719.72</b>	<b>57,257,691.82</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,275,457.00	16,077,290.00
210302	Түлш, халаалт	34,560,229.90	30,474,494.53
210303	Цэвэр, бохир ус	14,743,832.82	8,791,507.29
210304	Байрны түрээс	5,899,200.00	1,914,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,980,328.90</b>	<b>13,471,011.20</b>
210401	Бичиг хэрэг	1,574,220.00	941,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,591,517.90	8,785,733.20
210404	Ном, хэвлэл	4,814,591.00	3,743,878.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>599,250.00</b>	<b>558,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	599,250.00	558,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>98,244,819.00</b>	<b>184,322,583.00</b>
210604	Урсгал засвар	98,244,819.00	184,322,583.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,385,000.00</b>	<b>13,510,400.00</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,385,000.00	13,510,400.00



<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,537,993.58</b>	<b>14,601,094.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,179,620.00	14,125,844.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	210,973.58	145,250.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	147,400.00	330,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>550,820,206.55</b>	<b>608,428,211.73</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	482,058,756.55	572,783,270.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,761,450.00	35,644,941.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,200,000.00</b>	<b>3,235,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,200,000.00</b>	<b>3,235,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	3,235,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-80,204,149.03</u></b>	<b><u>70,677,528.97</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,328,300.00</b>	<b>14,611,192.68</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,328,300.00</b>	<b>14,611,192.68</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>27,328,300.00</b>	<b>14,611,192.68</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,328,300.00	14,611,192.68
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-27,328,300.00</u></b>	<b><u>-14,611,192.68</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-107,532,449.03</b>	<b>56,066,336.29</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>478,932,033.10</b>	<b>371,399,584.07</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>371,399,584.07</b>	<b>427,465,920.36</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Эдийн засгийн ангилал Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76,758,300,00	57,257,691,82	19,500,608,18	74.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,758,300,00	57,257,691,82	19,500,608,18	74.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,758,300,00	57,257,691,82	19,500,608,18	74.60
210301	Гэрэл, цахилгаан	20,000,000,00	16,077,290,00	3,922,710,00	80.40
210302	Түлш, халаалт	38,758,300,00	30,474,494,53	8,283,805,47	78.60
210303	Цэвэр, бохир ус	18,000,000,00	8,791,507,29	9,208,492,71	48.80
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>76,758,300,00</b>	<b>40,000,000,00</b>	<b>36.758.300.00</b>	<b>52.10</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>76,758,300,00</b>	<b>40,000,000,00</b>	<b>36.758.300.00</b>	<b>52.10</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих				
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>371,399,584,07</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>427,465,920,36</b>	<b>56,066,336,29</b>	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	110	110		
620001	Удирдах ажилтан	7	7		
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16		
620003	Үйлчлэх ажилтан	11	11		
620004	Багш /Гэрээт ажилтан/	76	76		

**5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл**

<b>Огноо:</b>	Аудитын нэр:	Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>
2019/03/15			САГ-2019/115/СТА-ТӨҮГ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		Улаанбаатарын их сургууль	<b>Сая төгрөгөөр:</b>

№	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Балансын данстай холбоотой асуудал	Санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын эцсийн үлдэгдэл няравын тайлангаас 1,576.5 мянган төгрөгөөр дутуу.	1.6	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
2	Балансын данстай холбоотой асуудал	Кассын няравын сар бүрийн тайланг хянаж баталгаажуулаагүй, кассын үлдэгдлийг тоолж, актаар баталгаажуулаагүй.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
3	Балансын данстай холбоотой асуудал	2017 оны 12 сарын 31-ний байдлаарх НДШ-ийн авлагын үлдэгдэл 1,475.4 мянган төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй.	1.5	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
4	Орлогын данстай холбоотой асуудал	Нийгмийн даатгалын байгууллагаас буцаан олгосон 687.3 мянган төгрөгийн шимтгэлийг орлогоор бүртгэж, НДШ-ийн өглөгийг бууруулж тайлагнаагүй.	0.7	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
5	Балансын данстай холбоотой асуудал	Татвар, Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Сургалтын төлбөрийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	0.3	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

		Шилэн дансны нэгдсэн цахим системд 3 чиглэлийн 18 төрлийн мэдээ мэдээлэхээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 5 мэдээ, эхний хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлж, бусад мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
6	Зардлын данстай холбоотой асуудал	1. Ажилтнуудад олгосон цалин, урамшуулалд даатгуулагчийн 2,644.5 мянга, ажил олгогчийн 2,884.9 мянга, нийт 5,529.5 мянган төгрөгийн НДШ, 823.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тус тус ногдуулаагүй. 2. Ажилтанд олгосон цалин урамшууллаас 1,912.8 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан боловч, татварт мэдүүлж, тайлагнаагүй.	8.3	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ахлах нягтлан бодогч	С.Байгалсайхан О.Туяа
			<b>12.4</b>			